

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20... оны ... сарын ... ны өдөр

№ ...

Улаанбаатар хот

“Байгаль орчин, нийгэм засаглалын бодлого”-ыг шинээр батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн холбогдох хэсгүүдийг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Сэндли ББСБ” ХК-ийн “Байгаль орчин, нийгэм засаглалын бодлого”-ыг хавсралтаар шинээр батласугай.
2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/, Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан захирал /Д.Баярбат/ нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАНБАТ





БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Сэндли ББСБ ХК (цаашид “ББСБ” гэх)-ын бизнесийн болон дотоодын үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэм болон зохистой засаглалын талаар баримтлах зарчмыг тодорхойлох, үүсэх эрсдэлийг бууруулах, хянах, удирдах үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү бодлого нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилттой уялдаж, мөн ББСБ урт хугацаанд тогтвортой хөгжихийн тулд байгаль орчин, нийгэмд ээлтэй, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг дэмжих, зохистой засаглалын тогтолцоог бүрдүүлэх, Тогтвортой хөгжилд чиглэсэн санхүүгийн бүтээгдэхүүнийг бий болгож, ББСБ-ын дунд хугацааны стратеги төлөвлөгөө болон бизнес төлөвлөгөөнд тусгаж биелэлтийг хангаж ажиллана.
- 1.3 ББСБ нь Монгол Улсын “Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөр”-ийн бичиг баримтын “8 зарчим”-ыг үндэслэн боловсруулсан санал санаачилгыг дэмжин, зохион байгуулагдах нэгдсэн арга хэмжээнүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлж, ББСБ-ын үйл ажиллагаанд удирдлага болгон ажиллана.
- 1.4 ББСБ нь бизнесийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх Байгаль орчин, нийгэм, засаглал /цаашид “БОНЗ” гэх/-ын холбогдох асуудлууд, бодлогын хэрэгжилт, ТОС-ын үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөөг боловсруулж холбогдох удирдлагуудад танилцуулан шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг хянах зорилготой “Тогтвортой хөгжлийн ажлын хэсэг”-тэй байна.
- 1.5 ББСБ нь Тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэж, чадавхжуулах ба шаардлагатай хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны төсвийг санхүүгийн төлөвлөгөөнд тусгаж ажиллана.

Хоёр. Хамрах хүрээ

- 2.1 ББСБ энэхүү бодлогыг бүхий л үйл ажиллагаандаа баримтлан ажиллана.
- 2.2 Бодлого нь Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилт түүнтэй холбогдон гарсан эрх зүйн баримт бичгүүдтэй уялдсан байна.

Гурав. Нэр, томъёоны тодорхойлолт

- 3.1 Энэхүү бодлогод хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 3.1.1 “Монгол Улсын Тогтвортой Санхүүжилтийн хөтөлбөр” гэж Монгол Улсын Банк, санхүүгийн системд зохистой санхүүжилтийн үзэл баримтлал, тогтолцоог нэвтрүүлэх зорилго бүхий “Монгол Улсын нийгэм, байгаль орчинд ээлтэй тогтвортой санхүүжилтийн хөтөлбөр”-ийг,
 - 3.1.2 “Тогтвортой хөгжил” гэж хувь хүний болон байгууллагын хөгжлийн зорилтуудыг хангахын зэрэгцээ, Нийгэм, Байгалийн нөөц, экосистемийн тэнцвэрт байдлыг хангах чадварыг урт хугацаанд тогтвортой байлгах үйл явцыг,
 - 3.1.3 “Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэл” гэж байгаль, орчны хүчин зүйл, уур амьсгалын өөрчлөлтөөс үүсэх эрсдэл, нийгмийн харилцаанаас үүсэх эрсдэл болон компанийн засаглалын асуудлаас иргэн, хуулийн этгээдэд үүсэх эрсдэлийг,
 - 3.1.4 “Байгаль орчин, нийгэм, засаглалын үнэлгээ” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний явцад хүн амын эрүүл мэнд, байгаль орчин болон амьдрах орчин, тэдгээрийн хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөөнд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг урьдчилан тодорхойлох, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг,
 - 3.1.5 “Ногоон таксономи” гэж банк, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид болон бодлого боловсруулагчид ногоон зээл, хөрөнгө оруулалт оруулах төсөл, хөтөлбөрүүдийг тодорхойлохдоо ашиглах хүлэмжийн хий, агаар орчны бохирдлыг бууруулах, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааны ангилал, шалгуур үзүүлэлтийг,

- 3.1.6 “**Ногоон зээл**” гэж Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс баталсан “Монгол Улсын ногоон таксономи”-д тодорхойлогдсон ангилалд багтах үйл ажиллагааны салбарт оруулж буй санхүүжилтийг,
- 3.1.7 “**Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг**” – гэж Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр баталсан Монгол Улсын тогтвортой хөгжил, уур амьсгалын зорилтуудтай уялдсан, нэгдмэл, олон талт хамтын ажиллагааг хангасан, тогтвортой санхүүгийн системийг 2030 он хүртэл хөгжүүлэх, бүс нутагтаа тогтвортой санхүүгийн мэдлэг, манлайллын төв болох, үүнд шаардлагатай стратегийн чиглэл, арга хэмжээг тодорхойлох зорилго бүхий баримт бичгийг,
- 3.1.8 “**Жендэр**” гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг;

Дөрөв. Байгаль орчны талаар баримтлах зарчим

- 4.1 ББСБ нь Нэгдсэн Үндэстний Байгууллага /цаашид “НҮБ” гэх/-ын “Тогтвортой хөгжлийн зорилт” түүнд хүрэх дэлхий нийтийн урт хугацааны бодлогын баримт бичигт заасан Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах зорилтыг хэрэгжүүлэхэд анхаарч, санхүүжилтийн хөшүүргийг ашиглах замаар хүлэмжийн хийн ялгаралтын хэмжээг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас учрах сөрөг нөлөө, эрсдэлийг багасгах, түүнд дасан зохицох үндэсний зорилтод хувь нэмрээ оруулна.
- 4.2 ББСБ нь харилцагчийн байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийг үнэлэх, арилгах, бууруулах, тэдгээрийг удирдах зорилгоор уул уурхай, барилга, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлийн болон нэхмэлийн үйлдвэрлэлийн салбарын дэд ангилалд “Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд боловсруулсан тусгай шаардлагуудыг харилцагчид тавьж, хэрэгжүүлж ажиллана.
- 4.3 Монгол Улсын байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг даган мөрдөж, олон улсын санхүүгийн байгууллагын байгаль орчин нийгмийн талаарх сайн туршлагыг үйл ажиллагаанд нэвтрүүлж ажиллана.
- 4.4 Уур амьсгалын чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдэд тавигддаг байгаль орчин, нийгмийн эрсдэлийн шаардлагууд нь энэ бодлогын салшгүй хэсэг болох бөгөөд эдгээр олон улсын байгууллагуудтай тогтоох хамтын ажиллагааны суурь бичиг баримтын адил тооцогдож, хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 4.5 ББСБ нь байгаль орчин, нийгэмд ээлтэй, экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих бодлого баримталж, Монгол Улсын Засгийн газрын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, нийгмийн хөгжлийг дэмжих зорилгоор зээл олгох стратегийн зорилт тавин ажиллана.
- 4.6 Олон улсын гэрээ хэлэлцээр, конвенц, Монгол Улсын хууль тогтоомжоор хориглосон болон байгаль орчинд хор хөнөөл учруулах аливаа үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй.
- 4.7 ББСБ нь нийт ажилтан, харилцагч, хамтран ажиллагч иргэд, байгууллагууддаа хүрээлэн буй орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагааны талаарх мэдлэгийг түгээж ажиллана
- 4.8 ББСБ нь хөрс, ус, агаар, биологийн олон янз байдал, байгалийн сэргээгдэх болон сэргээгдэхгүй шавхагдаж буй нөөцийг хадгалан хамгаалж, тэдгээрт үзүүлэх сөрөг нөлөөллийг бага байхаар тогтвортой ашиглах хандлагыг дэмжин ажиллана.
- 4.9 ББСБ нь ногоон хөгжлийн төлөвлөгөөг жил бүр боловсруулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллана.

Тав. Нийгмийн бодлогын хүрээнд баримтлах зарчим

- 5.1 ББСБ нь Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт, соёлын өвийг хадгалах, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх зорилттой тус тус уялдуулан хүний эрх, жендэрийн эрх тэгш байдал болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

- 5.2 ББСБ нь Монгол Улсын түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх соёлын онцгой өв болох ёс заншил, хэл, бусад өв, түүнчлэн соёл, түүх, археологи, палентологийн түүх соёлын дурсгалыг хадгалж хамгаалах аливаа үйл ажиллагааг дэмжин ажиллана.
- 5.3 ББСБ нь хүний эрхийг хүндэтгэж, хөдөлмөрийн стандартыг мөрдөж, иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, тэдгээрийн аюулгүй байдлыг ханган ажиллахад хувь нэмрээ оруулж ажиллана
- 5.4 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгын хүрээнд, эмэгтэйчүүдийг санхүү, бизнесийн чиглэлээр чадавхжуулахад чиглэсэн төсөл, хөтөлбөр, ББСБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан дэмжлэг үзүүлнэ.

Зургаа. Засаглалын бодлого, зарчим

- 6.1 ББСБ-д зохистой засаглалын тогтолцоог бүрдүүлэх, түүний хэрэгжилтийг хангах зорилгын хүрээнд холбогдох хууль, тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс” болон бусад холбогдох эрхзүйн баримт бичгийг мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллана.
- 6.2 ББСБ нь Төлөөлөн Удирдах Зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/ нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална.
 - 6.2.1 ТУЗ нь ББСБ-ын БОНЗ-ын бодлогыг анхаарч, үйл ажиллагаанд хэрэгжүүлэх цар хүрээг тодорхойлж, дэмжиж ажиллана.
 - 6.2.2 Гүйцэтгэх удирдлага нь ББСБ-ын бизнес төлөвлөгөө, дунд хугацааны төлөвлөгөө болон санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд БОНЗ-ын асуудлыг тусгахад хяналт тавьж, дэмжиж ажиллана.
 - 6.2.3 ББСБ-д зохистой засаглалын тогтолцоог бүрдүүлэх, түүний хэрэгжилтийг хангах зорилгын хүрээнд холбогдох хууль, тогтоомж, дотоод журмын дагуу мэдээллийг ил тод тайлагнахад анхаарч ажиллана.
- 6.3 ББСБ-ын үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүргийг хүндэтгэн, байгаль орчин, нийгэм, засаглалын асуудлыг харгалзан оролцогч талуудад харилцан нөлөөлөх байдлыг үнэлж, аливаа шийдвэрийг гаргана.
- 6.4 Засаглалын бодлогын хүрээнд авлига, ёс зүйн асуудлыг бүхий л шатанд анхаарал хандуулж ажиллах бөгөөд “Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журам”-ыг ТУЗ-ийн хурлаар батлуулж, мөрдөнө.
- 6.5 ББСБ-ын “Тогтвортой хөгжлийн журам”-тай байх бөгөөд Гүйцэтгэх захирлаар батлуулж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

Долоо. Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн үнэлгээний тайлагнал

- 7.1 ББСБ нь ТоС Холбоо болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Олон улсын санхүүгийн корпораци, НҮБ-ын байгаль орчны хөтөлбөр, болон НҮБ ын хөгжлийн хөтөлбөртэй хамтран бэлтгэсэн “Монголын компаниудад зориулсан БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын удирдамж”-ийг ББСБ-ын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн үлгэрчилсэн байдлаар мөрдөж ажиллана.
- 7.2 ББСБ нь мэргэжлийн байгууллага эсхүл холбоодтой хамтран ажиллах замаар байгаль орчин, нийгэм засаглалтай холбоотой аливаа тайланг эх үүсвэр татах, энэ чиглэлийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор олон улсын тайлагналын дагуу хийж гүйцэтгэж болох ба дотоод болон гадаадын аудитын байгууллагаар үнэлүүлж, дүгнэлт гаргуулж болно.
- 7.3 ББСБ нь БОНЗ-ын бодлогын хэрэгжилтийг санхүүгийн тайлагналтай уялдуулан жилд нэг удаа ТУЗ –ийн хуралд тайлагнана.

Найм. Хяналт хариуцлага

- 8.1 Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлогыг хэрэгжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бий болгох, тайлагнахад ББСБ-ын бүх ажилтнууд чиг үүргийн хүрээнд тогтмол анхаарч ББСБ хамт олны үнэт зүйл, эрхэм зорилт, ёс зүйн үндсэн зарчим, хэм хэмжээг хатуу баримталж ажиллана.
- 8.2 Энэхүү бодлогын баримт бичгийг жил бүр шинэчлэн сайжруулна.